

**ХЯТАД МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ
ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА
ШИНЭ ЭРИНТЭЙ ЗОЛГОЖ БАЙНА**

*БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны
эдийн засаг худалдааны зөвлөх Сун Сюежун*

Хөгжлийн стратеги бүх талаар уялдан гүнзгийрч байна

- Хоёр талын удирдагчдын анхаарал, дэмжлэгийн дор Хятад, Монгол хоёр улс Хятадын талын “ Дэлхийн хөгжлийн санаачилга”, “ Бүс бас Зам” санаачилга болон Монголын талын “ Алсын хараа-2050” урт хугацааны бодлого, “ шинэ сэргэлтийн бодлого”, “ Талын зам” хөтөлбөрийн стратегитай уядалдуулахад идэвхтэй түлхэц өгч, Хятад Монгол Оросын эдийн засгийн коридорыг хамтран байгуулж Хятад, Монголын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны урт хугацааны тогтвортой хөгжлийг ханган ажиллаж байна.

Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны механизм илүү төгөлдөржиж байна.

- Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Хятад-Монголын Засгийн газар хоорондын комисс, Хятад-Монголын эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны зөвлөл зэрэг хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны механизм өдөр ирэх тусам төгөлдөржин, хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд харилцааны сайн платформ болж байна. Хоёр тал эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны салбарын талаар хэд хэдэн чухал нэгдсэн ойлголтод хүрсэн бөгөөд “Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр” -г шинэчлэн боловсруулах ажлыг ойрын хугацаанд дуусгаж, Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэл, удирдамж болгохоор төлөвлөсөн.

ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЦАР ХҮРЭЭ ТАСРАЛТГҮЙ ӨРГӨЖИН ТЭЛЖ БАЙНА.

- 2021 онд Хятад, Монголын худалдааны хэмжээ 10 тэрбум ам.долларыг давж, өмнөх оны мөн үеэс 37.3%-аар өсч, мөн үеийн Монголын гадаад худалдааны нийт дүнгийн 63.1%-ийг эзлэв. Үүнээс БНХАУ-руу хийсэн экспортын хэмжээ 7.64 тэрбум ам.доллар болж, 39.2%-аар өссөн; БНХАУ-аас оруулсан импортын хэмжээ 2.52 тэрбум ам.доллар болж, 30.4%-аар өссөн; 2022 оны эхний 4 сарын байдлаар, БНХАУ-аас Монгол улсад оруулсан шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл 3.35 тэрбум ам.доллар болсон. Хятад улс 10 гаруй жил Монголын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулалтын чухал улс байсаар ирсэн. Хоёр талын худалдаа хүнд үеийг сөрөн өсөлттэй гарч, онцгой цаг үеийн Хятад, Монголын хамтын ажиллагааны бат бэх, эрчимтэй байдлыг бүрэн илтгэн харуулав.

Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны платформ нь эдийн засаг, худалдааны солилцоог дэмжиж байна

- Удаан хугацаанд Монгол улс нь Хятад улсын зохион байгуулдаг Хятадын олон улсын импортын экспо, Кантоны ярмаг, Зүүн хойд Азийн экспо, Хятад-Евроазийн экспо, Хятад-Монголын экспо, Хятад-Монгол-Оросын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны Эрээн хотын чуулга уулзалт зэрэг эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны чухал платформд идэвхтэй оролцсоор ирсэн бөгөөд Монгол улс платформуудыг ашиглан Хятад улстай эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаагаа идэвхтэй өргөжүүлж, Хятад улсын өөрчлөлт хөгжлийн шинэ үр ашгийг хуваалцахад тусалж дэмжинэ.

хоёр улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны төсөл амжилттай хэрэгжиж байна.

- Сүүлийн жилүүдэд хоёр улс хамтран Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тустай хэд хэдэн чухал төслүүдийг хэрэгжүүлэн, тус улсын анхны хурдны зам, анхны бүс нутаг дамнасан өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам болон Улаанбаатар хотын давхар гүүр, орон нутгийн автозам зэргийг бүтээн байгуулж; улсын хэмжээнд харилцаа холбооны үндсэн сүлжээ болон боловсрол, цахим эрүүл мэндийн сүлжээг бий болгоход тусалж, сургууль, цахилгаан станц, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв зэрэг иргэдийн амьжиргаанд тустай төслүүдийг хэрэгжүүлсэн нь Монголын төр болон ард түмний талархлыг хүлээсэн.

Эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны салбар тасралтгүй өргөжин тэлж байна.

- Хятад-Монголын Эрээн-Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хамтран байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хурдыг нэмэгдүүлнэ. Хоёр улсын хөгжлийн стратеги болон "Бүс ба Зам" санаачилгын уялдаа холбоог бэхжүүлэх хамтын ажиллагааны явц амжилттай үргэлжилж, хоёр улсын орон нутгийн хамтын ажиллагаа эрчимжиж, үндэсний мөнгөн тэмдэгтийн своп хэлцлийн хугацааг сунгаж, хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа гүнзгийрэн хөгжиж байна.

БАЯРЛАЛАА!

